

**“СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД” –ҮНДЭСНИЙ 2 ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Өмнөговь аймаг: Эрүүл мэндийн газар

2018.11.30

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	“Сэтгэцийн эрүүл мэнд хөтөлбөр”	Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, ахнах шатны болон нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар сэтгэц, зан зүйлийн эмгэгийн тархалтыг бууруулах нөхцөл бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, Орон нутгийн төсөв
3	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа: 2010-2019	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОЭТөв, Эрүүл мэндийн газар, ӨЭМТ, СЭМТөв, СДЭ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХҮГ, ЦГ
4	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ. Зорилт2. Сэтгэцийн эрүүл мэндийг хянаж сайжруулах талаар хувь хүний мэдлэг, чадварыг дээшлүүлэх Зорилт3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд нийгэм, хамт олны оролцоог нэмэгдүүлэх Зорилт4. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмж чанарыг сайжруулах Зорилт5. Сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох СЭМ-ийн эмгэгийн тандалтыг сайжруулах
6	Хөтөлбөрийн зорилт:	Биелэлт 87%
	1-р зорилтын хүрээнд: сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ.	Сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 8 арга хэмжээг зохион байгуулж байна. Албан байгууллагууд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах тал дээр анхааран ажиллаж 2018 онд шатлалаа ахиулах, шинээр болзол хангах хүсэлт 17 байгууллагаас хүлээж аваад байна. Байгууллагууд ажилчдын ая тухтай орчинг бүрдүүлэх амрах өрөө тохижуулах зэргээр түлхүү анхаарч ажилласан бөгөөд аймгийн хэмжээнд 19 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага

		<p>болоод байна.</p> <p>Даланзадгад сум болон Цогт цэцэий сумдад Өсвөр үед ээлтэй клиник ажиллаж байна. Уг клиник нь өсвөр үе, залуучуудад сэтгэлзүйн зөвлөгөөг хүргэж ажиллаж байна.</p> <p>Сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан 251 иргэнийг эмнэлэг хөдөлмөр магадлах комиссоор оруулж нийгмийн халамж үйлчилгээнд хамруулж ажилласан байна.</p> <p>Мөн 4 нэр төрлөөр сэтгэц нөлөөт төрбөрийг нь төр хариуцдаг эмийг 65 гаруй үйлчлүүлэгчид олгосон байна. Аймгийн БОЭТөв нь сэтгэц наркологийн тусламж үйлчилгээг хэвтэн эмчлүүлэх 5 ортой ажиллаж 210 үйлчлүүлэгчийг эмчилгээнд хамруулснаас архины хордлого тайлах эмчилгээнд 160, ядаргаа болон бусад эмгэгийн учир 50 гаруй үйлчлүүлэгч хэвтэг эмчлүүсэн байна.</p> <p>ХХҮХэлтэстэй хамтран сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чавдар алдсан 36 үйлчлүүлэгчийг нийгэм хамт олны нөхөн сэргээх эмчилгээнд хамруулж сургалтанд явуулж байна.</p> <p>ХГБЗХГ-ын дэргэдэх сэтгэл зүйн 2 төв ажилласнаар давхардсан тоогоор 1500 иргэнд зөвлөгөө өвч, 45 гэр бүлийн асуудалтай өрх гэр бүлд хамтарсан багаар ажиллаж, 23 өрхийг гэр бүлийн салалтаас сэргийлсэн байна. Мөн өсвөр насны хүүхдийн зан байдал, бусдад уруу татагдаж гэмт хэрэгт холбогдох зэргээс сэргийлэх сургалтыг хийн 560 гаруй хүүхэд хамруулсан.</p>
	<p>2-р зорилтын хүрээнд: сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах талаар хувь хүний мэдлэг, чадварыг дээшлүүлнэ</p>	<p>Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 2 бясалгал болон 2 сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажиллаж буй төвүүдтэй хамтран ажиллаж иргэдийг хамруулж сэтгэцийн эрүүл мэндийг дэмжин ажиллаж байна.</p> <p>Сэтгэцийн эрүүл мэндийн байдал, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор албан байгууллагын ажилчдад Баян-овоо, Манлай, Цогт-овоо сумдууд “Ажлын байрны стресс бухимдалыг хэрхэн зөв тайлах вэ”, “Уур бухимдал ба эрүүл мэнд” сэдвүүдээр сургалт хийн 3 төрлийн санамж, зөвлөмжийг 500 ширхэгийг тараасан байна. Сургалтанд нийтдээ 693 хүн хамрагдсан. Дэлгэцийн донтолт сэдвээр ЕБС-ийн сурагчдад 10 удаа, нийтдээ 1263 хүүхдэд видео болон зурган сургалтыг явуулсан байна.</p> <p>Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, ажлын байрны стрессээс сэргийлэх чиглэлээр 15 сумын хүрээнд ЭМБ-ууд нийт 8879 хүнд сургалт, сурталчилгааг хийсэн байна.</p> <p>Жил бүрийн 10 сарын сүүлийн 7 хоногийг сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх 7хоног болгон тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ өдрийг тохиолдуулан “Сэтгэцийн эмгэг танд ч бас надад тулгарна” уриан дор зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд Манлай, Хүрмэн, Номгон, Ханхонгор, Цогт-овоо, Баяндалай, Баян-овоо сумдууд идэвхтэй төлөвлөгөө гарган ажиллаж, нийт 1500 гаруй иргэнд сэтгэцийн</p>

		эрүүл мэндийн талаарх ойлголт, тулгамдсан асуудал сэдвийн хүрээнд уралдаан тэмцээн, сургалт хүргэсэн байна. Мөн сэтгэцийн эмгэгтэй, байнгын асаргаатай иргэдийн ар гэр, асран хамгаалагч нарт чиглэсэн сургалт зөвлөгөөг өргөн хүрээнд зохион байгуулсан байна. Энэхүү тэмдэглэлт өдрийн хүрээнд нийтдээ 2000 хүнд гарын авлага зөвлөмжийг тараасан байна.
	3-р зорилтын хүрээнд: сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих ажиллагаанд нийгэм хамт олны оролцоог нэмэгдүүлнэ.	Ард иргэдийн эрүүл мэндийг дэмжих чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх болон стресс бухимдлаас ангид байх зорилгоор өглөөний дасгал хөдөлгөөн бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулж байна. 15 сумын хэмжээнд нийт 136 байгууллага, 271 хувь хүн 2 сарын хугацаанд 36,000 гаруй иргэд хамрагдсан байна.
	4-р зорилтын хүрээнд: сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж чанарыг сайжруулна.	СЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах хүрээнд өрх сумын эмч нарын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Сэтгэцийн эмгэгтэй хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн үзлэгийн хяналтыг өрх сумын эмч нараар хийлгэж хамтран ажиллаж эмч нарын мэдлэгийг нэмэгдүүлж, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чирэгдэлийг бууруулан байна.
	5-р зорилтын хүрээнд: хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл, зонхилон тохиолдох эмгэгийн тандалтыг сайжруулна.	Аймгийн хэмжээнд архигүй Өмнөговь хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд 2018 оны 11 сарын байдлаар Даланзадгад сумын хэмжээнд архины байнгын хамааралтай 56 хүн бүртгэгдэж 15 хүнийг албадан эмчилгээнд орон нутгийн төсвөөс явуулаад байна.
7	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/	<ol style="list-style-type: none"> 1. Ололттой тал- анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нь уг хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. 2. Дутагдалтай тал- салбар бүрийн хамтын оролцоо хангалтгүй байна. Мөн санхүүгийн хуьд хангалтгүй байдаг. 3. Анхаарах асуудлууд- Хөтөлбөрийг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх болон, шинээр гарсан хөтөлбөрт, ард иргэдийн үүрэг болон, холбогдох ААН, байгууллагын үүрэг, хамтын оролцоог тусгаж өгөх нь зүйтэй байна. Мөн хүний нөөцийн асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Хөтөлбөрийн үр дүн төдийлөн харагдахгүй байна. <p>Орон нутгийн төдийгүй анхан шатны эрүүл мэндийн байгууллагун эмч мэргэжилтэнг чадавхижуулах хэрэгцээ шаардлага байна.</p> <p>Сэтгэцийн эмгэгийн урьдчилан сэргийлэлт эмчилгээ асуудалд ӨЭМТ, СЭМТ-ийн эмч мэргэжилтэнг чадавхижуулах нь чухал байна. Сэтгэцийн эрүүл мэндийн талаар ард иргэдийн ойлголт, мэдлэг хандлага дутмаг байдаг нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж байна. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхан шатны тусламж үйлчилгээний орчин нөхцөлийг дэмжих мөн эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах ажил</p>

		чухал байдаг. БОЭТ-д сэтгэц, наркологийн тасаг байгуулах шаардлагтай байгаа. Одоо ажиллаж байгаа кабинетын хувьд үйл ажиллагаа нь төдийлөн өргөн хүрээг хамарч чадахгүй, хүний нөөцийн хувьд дутагдалтай ажиллаж байна. Хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэхийг тулд төсөв санхүүг хангалттай хуваарилах, салбар хоорондын ахмтын оролцоо, эмч, мэргэжилтэнг чадавхижуулан сургах шаардлагатай байна.						
8	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /Өөрийн үнэлгээ/	Биелэлт дундаж 87%	Зорилтын тоо 5	Зорилт 1 90%	Зорилт 2 90%	Зорилт 3 85%	Зорилт 4 85%	Зорилт 5 85%

Шалгуур үзүүлэлт

Үзүүлэлт	2009 оны суурь түвшин	2014 онд хүрэх түвшин	2019 онд хүрэх түвшин	Мэдээний эх үүсвэр
Нэг				
Эрүүл мэндийг дэмжигч байгууллага аж ахуйн нэгжийн тоо		20%-иар нэмэгдүүлж шалгууртаа хүрсэн байна	50% нэмэгдсэн	Батламж авсан байгууллагын тоогоор
Эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлсэн сэтгэц нөлөөт шинэ эмийн тоо, төрөл		1 төрлийн эм \ рексетин \	4	Эмийн эмчилгээний хорооны тайлан
Сэтгэцийн эрүүл мэндийн сургалтанд хамрагдсан цагдаа, шүүх, хуулийн ажилтаны эзлэх хувь	20	50%-д хүрч ажилласан	70%	Сургалтанд хамрагдсан хүний тоо, хувь
Хоёр. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх талаар				
Сэтгэцийн эрүүл мэндийн талаар ажил зохион байгуулдаг ЕБС-ын эзлэх хувь	0	0	70%	БСУГ-ын тайлан
Гурав. Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх талаар				

	Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг ТББ-ын тоо	0	2 бясалгалын төв ажиллаж байна.	2	ТББ-ын тайлан статистик мэдээ
Дөрөв. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгож хүртээмж чанарыг сайжруулах талаар					
		0	Байхгүй хэрэгжээгүй	1	
	Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатный тусламж үйлчилгээний талаар сургалтанд хамрагдсан сум, өрхийн эмчийн эзлэх хувь	20%	Бүрэн хамруулж ажилласан нийт 64 хүн сургалтанд хамрагдсан	60%	Сургалтанд хамрагдсан хүний тоо, хувь, хөтөлбөрийн тайлан
	Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтанд орсон сэтгэц нөлөөт эмээр хангагдсан эмнэлгийн хувь	60%	100% тараагдаж биелэлтийг хангаж ажилласан байна.	85%	Хангагдсан эмнэлгийн тоо, нэр

Тайлан бичсэн:

НЭМТ-ийн мэргэжилтэн Б.Ганцэцэг